

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/121/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУБ	Олон улсын байгууллага
ЭАЭЗ	Эхэлж авснаа эхэлж зарлагдах
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/84
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.МЯДАГМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020300

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,433,240.98	103,146,624.02
35	БАРАА МАТЕРИАЛ	90,433,240.98	103,146,624.02
351	Түүхий эд материал	52,640,712.54	55,321,089.10
35110	Тусгай зориулалттай материал	52,512,362.50	55,192,739.06
35130	Эм боох материал	128,350.04	128,350.04
354	Хангамжийн материал	37,792,528.44	47,825,534.92
35410	Бичиг хэргийн материал	943,200.00	1,664,500.00
35420	Аж ахуйн материал	31,340,480.00	34,637,730.00
35460	Хүнсний материал	3,914,008.44	9,766,964.92
35470	Бусад хангамжийн материал	1,594,840.00	1,756,340.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,243,187,230.00	1,261,012,195.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,243,187,230.00	1,261,012,195.58
392	Биет хөрөнгө	1,220,075,230.00	1,237,900,195.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,237,016,780.81	1,284,911,830.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65,565,823.06	-94,372,942.06
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,227,937.00	74,746,438.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,361,023.57	-58,118,616.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,288,356.60	50,730,804.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,259,252.09	-34,038,092.95
39217	Ном	13,728,254.31	14,040,772.99
393	Биет бус хөрөнгө	23,112,000.00	23,112,000.00
39301	Программ хангамж	499,500.00	499,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-499,500.00	-499,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,112,000.00	23,112,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,333,620,470.98	1,364,158,819.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,769,228.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,769,228.00
413	Өглөг	00.00	6,769,228.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	6,769,228.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,333,620,470.98	1,357,389,591.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,333,620,470.98	1,357,389,591.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,692,885,199.00	1,692,885,199.00
51101	Өмч: - төрийн	1,692,885,199.00	1,692,885,199.00
512	Хуримтлагдсан үр дүн	-507,359,801.15	-480,743,181.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-507,359,801.15	-504,512,302.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	23,769,120.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	148,095,073.13	145,247,574.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,333,620,470.98	1,364,158,819.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	676,158,495.50	716,692,969.52	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,336,395.50	56,763,439.52	
120	Нийтлэг татварын бус орлого	16,336,395.50	56,763,439.52	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,336,395.50	56,763,439.52	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,336,395.50	56,763,439.52	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	129,283,500.00	149,167,130.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	530,538,600.00	510,762,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,751,400.00	29,734,030.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,751,400.00	29,734,030.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,532,100.00	119,433,100.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,532,100.00	119,433,100.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	703,039,063.46	690,487,201.72	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	703,039,063.46	690,487,201.72	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,335,162.79	615,840,035.33	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,192,380.00	389,558,727.31	
210101	Үндсэн цалин	261,177,644.00	254,749,950.00	
210102	Нэмэгдэл	90,954,747.00	95,733,378.31	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,208,408.00	9,002,000.00	
210104	Урамшуулал	22,851,581.00	30,073,399.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,514,591.47	49,575,848.00	
210201	Тэтгэврийн даатгал	44,395,036.95	49,575,848.00	
210202	Тэтгэмжийн даатгал	1,043,454.20	00.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	834,762.81	00.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	203,759.21	00.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	2,037,578.30	00.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,528,463.00	116,368,772.00	
210301	Гэрэл, цахилгаан	4,817,648.00	6,184,599.00	
210302	Түлш, халаалт	103,510,815.00	109,984,173.00	
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	2,338,890.00	4,033,200.00	
210401	Бичиг хэрэг	336,000.00	382,400.00	
210402	Тээвэр, шатахуун	557,490.00	337,200.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	463,000.00	500,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	80,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	982,400.00	2,733,600.00	
2105	Нормативт зардал	13,802,052.36	17,350,427.82	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	645,115.00	215,600.00	
210502	Хоол, хүнс	11,458,094.86	17,134,827.82	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,698,842.50	00.00	

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,262,000.00	650,000.00
210604	Урсгал засвар	1,262,000.00	650,000.00
2107	Томилолт, зочны зардал	176,000.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	176,000.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,650.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,650.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,347,135.96	38,096,060.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	584,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	1,765,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,967,135.96	35,746,450.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,703,900.67	74,647,166.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,614,639.14	34,047,625.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,087,489.14	7,843,925.70
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,632,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,751,400.00	14,730,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	775,750.00	840,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80,089,261.53	40,599,540.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,089,261.53	40,599,540.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,880,567.96	23,769,120.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,436,647.18
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,436,647.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,880,567.96	23,769,120.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,669,773,199.00	00.00	-267,918,331.78	1,401,854,867.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,669,773,199.00	00.00	-267,918,331.78	1,401,854,867.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,723,658.68	5,723,658.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,692,885,199.00	148,095,073.13	-507,359,801.15	1,333,620,470.98
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,692,885,199.00	148,095,073.13	-507,359,801.15	1,333,620,470.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,847,498.71	2,847,498.71
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,692,885,199.00	148,095,073.13	-504,512,302.44	1,336,467,969.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,847,498.71	00.00	-2,847,498.71
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,769,120.62	23,769,120.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,692,885,199.00	145,247,574.42	-480,743,181.82	1,357,389,591.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	659,822,100.00	659,929,530.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	659,822,100.00	659,929,530.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	530,538,600.00	510,762,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,751,400.00	29,734,030.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,751,400.00	29,734,030.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	112,532,100.00	119,433,100.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	112,532,100.00	119,433,100.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	659,554,750.00	659,046,530.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	659,554,750.00	659,046,530.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,829,114.47	583,854,299.31	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,201,380.00	389,558,727.51	
210101	Үндсэн цалин	261,186,644.00	254,749,949.51	
210102	Нэмэгдэл	90,954,747.00	95,733,379.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,208,408.00	9,002,000.00	
210104	Урамшуулал	22,851,581.00	30,073,399.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,514,591.47	49,575,847.80	
210201	Тэтгэврийн даатгал	44,395,037.35	34,663,697.36	
210202	Тэтгэмжийн даатгал	1,043,454.20	3,765,783.89	
210203	ҮОМШӨ-ний даатгал	834,762.41	3,089,785.37	
210204	Ажилгүйдлийн даатгал	203,759.21	732,368.08	
210205	Эрүүл мэндийн даатгал	2,037,578.30	7,324,213.10	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,528,463.00	109,599,544.00	
210301	Гэрэл, цахилгаан	4,817,648.00	6,184,599.00	
210302	Түлш, халаалт	103,510,815.00	103,214,945.00	
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,506,440.00	2,000,610.00	
210401	Бичиг хэрэг	264,000.00	350,000.00	
210402	Тээвэр, шатахуун	462,090.00	474,260.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000.00	500,000.00	
210404	Ном, хэвлэл	25,500.00	00.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	164,850.00	145,600.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,005,000.00	530,750.00	
2105	Нормативт зардал	10,154,290.00	25,144,320.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00	250,000.00	
210502	Хоол, хүнс	8,754,290.00	22,460,720.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,260,000.00	2,433,600.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	176,000.00	207,000.00
210702	Дотоод албан томилолт	176,000.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	530,650.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,650.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,217,300.00	6,768,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,700.00	1,399,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,028,600.00	5,368,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,725,635.53	75,192,230.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,636,374.00	34,592,690.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,109,224.00	8,370,990.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,632,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,751,400.00	14,730,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	775,750.00	858,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80,089,261.53	40,599,540.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,089,261.53	40,599,540.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>267,350.00</u>	<u>883,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	883,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	883,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	883,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	883,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-883,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	630,195,500.0	588,783,289.3	41,412,210.7	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,195,500.0	588,783,289.3	41,412,210.7	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,519,100.0	579,554,299.3	39,964,800.7	93.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,601,600.0	389,558,727.5	20,042,872.5	95.1
210101	Үндсэн цалин	279,801,500.0	254,749,949.5	25,051,550.5	91.0
210102	Нэмэгдэл	89,671,800.0	95,733,379.0	(6,061,579.0)	106.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,860,000.0	9,002,000.0	4,858,000.0	64.9
210104	Урамшуулал	26,268,300.0	30,073,399.0	(3,805,099.0)	114.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,296,200.0	49,575,847.8	5,720,352.2	89.7
210201	Тэтгэврийн даатгал	45,608,100.0	34,663,697.4	10,944,402.6	76.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,422,000.0	3,765,783.9	(1,343,783.9)	155.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,937,700.0	3,089,785.4	(1,152,085.4)	159.5
210204	Ажилгүйдлийн даатгал	484,400.0	732,368.1	(247,968.1)	151.2
210205	Эрүүл мэндийн даатгал	4,844,000.0	7,324,213.1	(2,480,213.1)	151.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,433,100.0	109,599,544.0	8,833,556.0	92.5
210301	Гэрэл, цахилгаан	7,821,600.0	6,184,599.0	1,637,001.0	79.1
210302	Түлш, халаалт	110,411,500.0	103,214,945.0	7,196,555.0	93.5
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	200,000.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,795,000.0	2,000,610.0	1,794,390.0	52.7
210401	Бичиг хэрэг	350,000.0	350,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	474,260.0	25,740.0	94.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	500,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	285,000.0	-	285,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	145,600.0	14,400.0	91.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	530,750.0	1,469,250.0	26.5
2105	Нормативт зардал	28,698,200.0	25,144,320.0	3,553,880.0	87.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.0	250,000.0	250,000.0	50.0
210502	Хоол, хүнс	25,498,200.0	22,460,720.0	3,037,480.0	88.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.0	2,433,600.0	266,400.0	90.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	223,000.0	207,000.0	16,000.0	92.8
210702	Дотоод албан томилолт	223,000.0	207,000.0	16,000.0	92.8
2109	Бараа үйлчилгээний бусад				

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	зардал	2,472,000.0	2,468,250.0	3,750.0	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.0	1,399,800.0	200.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,072,000.0	1,068,450.0	3,550.0	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,676,400.0	9,228,990.0	1,447,410.0	86.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,676,400.0	9,228,990.0	1,447,410.0	86.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,755,900.0	8,370,990.0	1,384,910.0	85.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	858,000.0	62,500.0	93.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	630,195,500.0	630,195,500.0	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510,762,400.0	510,762,400.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510,762,400.0	510,762,400.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,433,100.0	119,433,100.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	119,433,100.0	119,433,100.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	34.0	34.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	15.0	15.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,663,700.00	29,663,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,663,700.00	29,663,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,300,000.00	4,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000.00	4,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,363,700.00	25,363,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,363,700.00	25,363,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,632,900.00	10,632,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,730,800.00	14,730,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,663,700.00	29,663,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,663,700.00	29,663,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,663,700.00	29,663,700.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, анхан шатны баримт материалд үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэж тайлагнаж байх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн аюулгүй, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн хүмүүжил, хөгжил, төлөвшил, сурлагын чанарт ахиц гаргахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн Захирлын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/14 дугаар тушаалаар сургуулийн хоол үйлдвэрлэл,

үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2019, 2020 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 630,195.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,452.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,089.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 630,195.5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 29,734.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 659,046,5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 47,895.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 2,697.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,925.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,490.5 мянган төгрөгийн ном, нийт 56,008.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,210.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 52,797.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 3,965.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 38,382.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 29,634.9 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэлгүй, 6,769.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 103,146.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,261,012.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	90,433.24	103,146.62	12,713.38
Үндсэн хөрөнгө	1,243,187.23	1,261,012.20	17,824.97
Нийт хөрөнгө	1,333,620.47	1,364,158.82	30,538.35
Өр төлбөр	-	6,769.22	6,769.22
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,333,620.47	1,357,389.60	23,769.13
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,333,620.47	1,364,158.82	30,538.35

Бараа материалын дансны үлдэгдэл 103,146.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 12,713.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,261,012.2 мянган төгрөг болж 17,824.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,357,389.6 мянган төгрөг болж 23,769.1 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 630,195.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 619,519.1 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 10,676.4 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 619,519.1 мянган төгрөгийн урсгал зардал, 10,676.4 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 630,195.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 588,783.3 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 41,412.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588,783.3 мянган төгрөг буюу 93.4 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 29,663.7 мянган төгрөг төвлөрч, урсгалд зардалд 29,663.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 47,895.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 2,697.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,925.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,490.5 мянган төгрөгийн ном, нийт 56,008.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,210.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 52,797.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тус сумын 1 дүгээр багийн малчин 1,000.0 мянган төгрөгийн, төгсөгчдөө 500.0 мянган төгрөгийн, цээл багийн иргэдээс дотуур байрны гал тогоонд 1,300.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг хандивласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 63 нэр төрлийн 57,200.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3 нэр төрлийн 499.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй, бараа материалын дансанд 13 нэр төрлийн 6,010.0 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 16 нэр төрлийн 892.0 мянган төгрөгийн хүнсний материал, 22 нэр төрлийн 128.4 мянган төгрөгийн үнэ бүхий эм тус тус бүртгэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 141 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,120.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Бодь тусгал Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72,141.0 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 221.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6,769.2 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, 65,150.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 221.8 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Дэлхийн зөн Монгол ОУБ-аас “Орон нутгийн хөтөлбөр 2021” хүрээнд үнэ төлбөргүй олгосон 221.8 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг орлогоор бүртгэж тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгагдсан халаалтын 6,769.2 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 63 нэр төрлийн 57,200.2 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 13 нэр төрлийн 6,010.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоолын 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн анги доторхи зүйлийг НББОУС-д нийцүүлэн зөв ангилан бүртгэх, буруу бүртгэснийг данс хооронд шилжүүлэх замаар залруулан бүртгэхийг дарга, захирал нарт даалгасугай”, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэх

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 16 нэр төрлийн 892.0 мянган төгрөгийн хүнсний материал, 22 нэр төрлийн 128.4 мянган төгрөгийн үнэ бүхий эм бүртгэлтэй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.22-д “Төсөвт байгууллага нь бараа материалын өртгийг тодорхойлохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг ашиглана. Эхэлж авсныг эхэлж зарлагадах аргын үед эхэлж худалдан авсан бараа материалыг эхэлж зарцуулна” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зарцуулахдаа ЭАЭЗ аргыг ашиглаж хэвших, бараа материалын бүртгэлийг сайжруулах

4. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 499.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны 1 албан хаагчийн цалинг НДШ төлөлтийн тайланд 420.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

НДШ төлөлтийн тайланг цалингийн цэс болон анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв тайлагнаж байх

6. Шилэн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 141 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Ерөнхий боловсролын сургууль	8	72,141.0	1	221.8	-	-	1	6,769.2	6	65,150.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn